



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 759

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, засаж сэлбэн ашиглах боломжгүй нь өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлтээр нотлогдсон 4 нэрийн, нийт 76,494,940.00 (далан зургаан сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга есөн зуун дөч) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал Г.Дашжанцан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө акталж данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 16 нын өдрийн
759 дугаар тогтоолын хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БҮСИЙН ОНОШЛОГОО,
ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

ATA11111 6098169 9023120816

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Явсан гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/
1	Dong FDong Feng, ZN5030, Арлын дугаар-LJNMFMBX29N042911, Улсын дугаар-1774ӨВА	2009-12-01	165857	40,984,710.00
2	TIANMA KZ-6490, Арлын дугаар-LHA1203D79A006530, Улсын дугаар-9826ӨВА	2008-12-29	155302	21,835,000.00
3	УАЗ-469, Арлын дугаар-7056541, Улсын дугаар 7542ӨВА	2007-06-19	207269	13,675,200.00
4	УАЗ- 469, Арлын дугаар-50519761, Улсын дугаар-5803ӨВА	2005-06-02	330314	12,506,111.00
НИЙТ ДҮН				76,494,910.00
				(далан зургаан сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга есөн зуун арван төгрөг)